



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/90

Улаанбаатар хот

Төлбөртэй тусламж үйлчилгээ үзүүлэх журам шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.3, 24.4, 24.5 дахь заалт, "Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль"-ийн 18, 19 дүгээр зүйл, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн "Төлбөрийн жишиг хэмжээний журам батлах тухай" 49/A/118 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/216 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын хамтран баталсан 2023 оны А/483, А/200 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хан-Уул Эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 49/A/118 дугаар тушаалын хүрээнд төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг мөрдлөг болгон ажиллах, "Төлбөрт тусламж үйлчилгээний журам"-ыг нэгдүгээр, Эрүүл мэндийн даатгалын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээг хоёрдугаар, "Гадаадын иргэнийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, шинжилгээнд хамруулах төлбөр"-ийн хэмжээг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлбөртэй тусламж үйлчилгээ, төлбөрийн жишиг хэмжээг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт ил тод байршуулан иргэдийг мэдээллээр хангах, эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэл болон санхүүгийн программд зохих өөрчлөлтийг хийж хоорондын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээг авч ажиллахыг Программ хангамж хариуцсан мэргэжилтэн (Б.Түвшинжаргал)-д үүрэг болгосугай.

3. Төлбөртэй тусламж үйлчилгээний журмыг хэрэгжүүлж тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, зохион байгуулж ажиллахыг Амбулаторийн эрхлэгч (Д.Молор-Эрдэнэ), Хэвтэн эмчлүүлэх тасгийн эрхлэгч (П.Батчимэг), Хүлээн авах яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч (Б.Намуунбайгаль) нарт, Төлбөртэй тусламж үйлчилгээ, орлогыг нягтлан бодох бүртгэлд тусган зориулалтын дагуу зарцуулж, тайлагнахыг Санхүүгийн албаны дарга (С.Оюун-Эрдэнэ) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж, нийт

ажилтнуудад танилцуулж, 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн орлогч дарга (Т.Мөнхдэлгэр)-т даалгасугай.

5.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн "Төлбөртэй тусламж үйлчилгээний журам шинэчлэн батлах тухай" А/58 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ХҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.НАРАНБААТАР



82

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2025 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн
А/90 дугаар тушаалын 1/А хавсралт

ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар Хан-Уул Эрүүл мэндийн төв /цаашид "ХУЭМТөв" гэх /-ээр үйлчлүүлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хүсэлтээр үзүүлж буй нэмэлт болон эмнэлгийн зарим тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ оношилгоо, үйлчилгээг төлбөртэй үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

ХОЁР. ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Төлбөртэй үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт болон үнийн жишиг, төлбөр төлөх журмыг үйлчлүүлэгчдэд ил тод байршуулж, кассын нярав болон эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн ажилтан хариуцан ажиллана.

2.2. Төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогыг эмнэлгийн кассаар болон үндсэн үйл ажиллагааны орлогын бүртгэлд бүртгэх, эмнэлгийн цахим бүртгэл, санхүүгийн программыг ашиглан төрийн сангийн төвийн төсвийн харилцах дансанд төвлөрүүлэх ба энэхүү ажлыг санхүү бүртгэлийн асуудал эрхэлсэн нэгж хариуцан зохион байгуулна.

2.3. Төлбөрт үйлчилгээ авсан иргэний төлбөр төлсөн баримтад /E-BARIMT/ эмнэлэг, эмчийн нэр, үзүүлсэн тусламж үйлчилгээний төрөл, тусламж үйлчилгээ нэг бүрийн болон нийт төлбөрийн дүн, үүнээс эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн дүн, үйлчлүүлэгчийн төлсөн төлбөрийн дүн, төлбөр төлсөн огноог тэмдэглэнэ.

2.4. Төлбөрт тусламж үйлчилгээний мэдээллийг төвийн мэдээллийн самбарт байршуулах, төлбөр тооцооны эрсдлээс ангид байх тухай мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулахыг мэдээлэл технологийн алба хариуцан ажиллана.

2.5. Төлбөртэй тусламж үйлчилгээг эмнэлгийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөхгүй байхаар зохицуулна.

2.6. Төлбөртэй тусламж үйлчилгээний орлогын тооцооллыг санхүүгийн албаны хариуцсан ажилтан сар бүрийн эхэнд үйлчилгээ тус бүрээр гүйцэтгэлд тулгуурлан гарган, энэ тушаалын хавсралтын дагуу төлбөртэй хийгдэх тусламж, орлогын хуваарилалт, бодит өртгийн тооцооллыг гарган холбогдох алба, тасаг, холбогдох албан тушаалтыг мэдээллээр ханган ажиллана.

2.7. Төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогыг тухайн үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой гарч буй шууд зардал болон эмнэлгийн ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулна. Үйлчилгээ үзүүлэхэд гарах шууд зардалд дараах зардлууд хамаарна.

2.8.Эм, эмнэлгийн хэрэгсэл,ороох боох материал, урвалж бодис, ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал.

2.8.2. Эмч, эмнэлгийн ажилтны цалин

2.8.3. Багаж, тоног төхөөрөмж худалдан авах болон тэдгээрийн засвар үйлчилгээний зардал

2.8.4 Бусад зардал

ГУРАВ. ТӨЛБӨРТЭЙ ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

3.1.Даатгалаар хийх боломжгүй болон төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалтад хамрагдаагүй тусламж үйлчилгээг бодит өртгөөр тооцон үйлчилгээг үзүүлнэ.

3.2.Тухайн байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцсэн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг бусад эмнэлгийн байгууллагатай хамтын гэрээгээр гүйцэтгэнэ.

3.5.Эрүүл мэндийн төвийн захиргаанд байгууллага, аж ахуйн нэгж, дотоодын болон гадаадын иргэдийн урьдчилан сэргийлэх үзлэг, багцын шинжилгээ, төлбөртэй тусламж үйлчилгээнд хамрагдах хүсэлтийг үндэслэн үзлэг, шинжилгээ хийгдэнэ

ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ, БУСАД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

4.1.Урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн бусад үйлчилгээг Стратеги бодлого төлөвлөлтийн алба, Эрүүл мэндийг дэмжих төв, Поликлиникийн тасаг хамтран зохион байгуулна.

4.2.Урьдчилан сэргийлэх үзлэг,эрүүл мэндийн бусад үйлчилгээг авах аж ахуй нэгж байгууллага нь гэрээ байгуулах журмын дагуу Эрүүл мэндийн төвийн даргатай гэрээ байгуулан батлагдсан хуваарийн дагуу үзлэг, оношилгоо тусламж үйлчилгээндээ хамрагдана.

4.3.Урьдчилан сэргийлэх үзлэгийг захиалагч байгууллагын хүсэлтийг харгалзан тухайн эрүүл мэндийн төвийн байранд зохион байгуулна.

4.4.Урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн бусад үйлчилгээг авах хувь хүн сонгосон багцын төлбөрийг тушаан үзлэг, тусламж үйлчилгээг авна.

4.5.Урьдчилан сэргийлэх үзлэгээр, эмнэлзүйн урьдчилсан онош тавьсан тохиолдолд тус эмнэлгээр товлот цаг аван, дарааллын дагуу үйлчлүүлнэ.

4.6.Аж ахуй нэгж байгууллага нь гэрээнд заасны дагуу төлбөрийг 100% үзлэгийн өмнө төвийн харилцах дансанд шилжүүлсэн байна.

4.7.Урьдчилан сэргийлэх үзлэгт ажилласан эмч, сувилагч, бусад мэргэжилтнүүдэд нэмэлт ачаалал, ажлын гүйцэтгэлийг харгалзан үзэж байгууллагын дотоод журам болон хамтын гэрээний хүрээнд урамшууллыг олгоно.

ТАВ. НЭМЭЛТ ҮЗЛЭГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

5.1. Үйлчлүүлэгчдийн хүлээгдэл чирэгдэл бууруулах зорилготой амбулаторийн үзлэг, оношилгооны нэмэлт үзлэгийг зохион байгуулж болно. Үндсэн чиглэлийн үйлчилгээг алдагдуулахгүйгээр зохицуулсан байна.

5.2. Тогтоосон ажиллах цагт эсвэл амралтын өдрүүдэд нэмэлт тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулж болно.

5.3. Амралтын өдрүүдэд ажиллах хуваарийг амбулаторийн эрхлэгчид мэдэгдэж, үйл ажиллагааг хариуцан зохион байгуулна.

ЗУРГАА. ХОРИГЛОХ ЗҮЙЛ

6.1. Иргэдээс жагсаалтад зааснаас бусад тусламж үйлчилгээнд төлбөр авах, эмч мэргэжилтнүүд иргэдтэй бэлэн мөнгөөр тооцоо хийхийг хориглоно.

6.2. Байгууллагын ажлын үндсэн цагт багтаан үзүүлэх боломжтой тусламж, үйлчилгээг ажлын бус цагаар эсвэл бусад хэлбэрээр тохиролцон төлбөртэй үзүүлэхийг хориглоно.

6.3. Эмч, эмнэлгийн ажилтан ажлын байранд хувиараа эм, эмнэлгийн хэрэгсэл, био бэлдмэл, биологийн идэвхт бодис худалдаж авахыг санал болгохыг хориглоно.

ДОЛОО. ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ

7.1. Эмч, эмнэлгийн ажилтан нь эмнэлгийн тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэхдээ тус тусламж үйлчилгээнд зарцуулагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис, багаж тоног төхөөрөмж, эмнэлгийн ор, талбай, машин, техник, хүн хүч зэрэг нөөцийг эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байхаар зорицуулалтыг хийж ашиглана.

7.2. Иргэн эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар тухайн эрүүл мэндийн байгууллагын удирдлага, нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагуудад гомдол гаргах эрхтэй.

7.4. Байгууллага энэхүү тушаалыг зөрчиж, төлбөр авсныг эрх бүхий этгээд нотолсон тохиолдолд эрүүл мэндийн байгууллага иргэний төлбөрийг буцаан олгож, хохирлыг барагдуулна.

НАЙМ. ХАРИУЦЛАГА

8.1. Энэхүү журмаар тогтоосон, хориглох хэм хэмжээг зөрчсөн эмч, эмнэлгийн ажилтан, албан тушаалтанд Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, байгууллагын дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэж, учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

8.2. Энэхүү журмыг зөрчсөн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй байх тохиолдолд холбогдох хууль хяналтын байгууллагад хандан асуудлыг шийдвэрлүүлнэ.

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2025 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн
А/90 дугаар тушаалын 2р хавсралт




ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН БАГЦАД ХАМРАГДААГҮЙ
БУСАД ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Д/д	Тусламж үйлчилгээний төрөл	Тусламж үйлчилгээний нэр төрөл	Төлбөрийн хэмжээ
1	Донтолт, архидалтаас үүссэн гэмтэл, хордлогын оношилгоо, эмчилгээ	Донтолт, архидалтаас үүссэн гэмтэл, хордлогын оношилгоо, эмчилгээ	Бодит өртгөөр
2	Иргэн санаатайгаар амь насаа егүүтгэхээр оролдсон тохиолдолд эмнэлгийн тусламж үзүүлэх	Иргэн санаатайгаар амь насаа егүүтгэхээр оролдсон тохиолдолд эмнэлгийн тусламж үзүүлэх	Бодит өртгөөр
3	Оношийн хамаарлын бүлгийн жагсаалтад ороогүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Оношийн хамаарлын бүлгийн жагсаалтад ороогүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Бодит өртгөөр
4	Даатагалгүй гадаад иргэн хэвтэн эмчлүүлэх, өдрийн эмчилгээний тусламж үйлчилгээ авсан тохиолдолд	Оношийн хамаарлын бүлгээр	Бодит өртгөөр

86

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2025 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн
А/90 дугаар тушаалын 3р хавсралт



ГАДААДЫН ИРГЭНИЙГ ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭНД ХАМРУУЛАХ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Шинжилгээний нэр	Төлбөр /төгрөгөөр/
1	Хүний дархлал хомсдлын вирусийн халдвар илрүүлэх шинжилгээ	25,000
2	Тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээ	15,000
3	Цусанд хапатитын В вирусын халдвар илрүүлэх шинжилгээ	6,000
4	Цусанд хапатитын Ц вирусын халдвар илрүүлэх шинжилгээ	6,000
5	Сүрьеэгийн үзлэг шинжилгээ /цээж харалт/	10,000
6	Сэтгэл зүйн оношилгоо, сорил	30,000
	Нийт	92,000